

Хараат бус аудиторын дүгнэлт

Бид Соёмбо даатгал ХХК (цаашид "Компани" гэх)-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй болон тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Санхүүгийн тайлангийн талаарх удирдлагын үүрэг хариуцлага

Санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид СТОУС гэх) болон Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах нь компанийн удирдлагын үүрэг, хариуцлага юм. Алдаа, зальт ажиллагааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй санхүүгийн тайланг бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтыг хэрэгжүүлэх нь энэхүү хариуцлагад хамаарна.

Санхүүгийн тайлангийн талаарх аудиторын хариуцлага

Бидний үүрэг хариуцлага нь гүйцэтгэсэн аудитын ажилдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад хараат бус байдлаар дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж гүйцэтгэх ба мэргэжлийн ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөхийг биднээс шаарддаг.

Санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгын талаарх аудитын нотолгоог олж авахын тулд зохих горимуудыг гүйцэтгэх нь мөн аудитын ажилд багтдаг. Горимын сонголт нь аудиторын мэргэжлийн үнэлэлт дүгнэлтээс хамаарах бөгөөд үүнд залилан буюу алдааны улмаас санхүүгийн тайланг материаллагаар буруу илэрхийлэх эрсдэлийн үнэлгээ хамаарна. Эдгээр эрсдэлийн үнэлгээг хийхдээ аудитор нь компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт гаргах биш, харин тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг сонгох үүднээс компанийн санхүүгийн тайланг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулахтай холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Мөн компанийн удирдлагыг хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал, хийсэн тооцооллыг үндэслэл болон санхүүгийн тайлангийн ерөнхий тайлагналын байдлыг аудитын явца үнэлсэн.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай, зох үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

ний дүгнэлтээр, санхүүгийн тайлан нь компанийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайланг жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт болон Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан заавар журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Бусад

2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх болон тухайн өдрөөр дуусгавар болсон тайланг жилийн санхүүгийн тайланг өөр аудитор гүйцэтгэж, уг тайланд 2014 оны 2 дугаар сарын 27-ны өдөр зөрчилгүй дүгнэлт гаргасан болно. 2014 оны санхүүгийн тайлангийн зэрэгцүүлэх мэдээлэл нь уг зөрчилгүй дүгнэлт бүхий санхүүгийн тайланд үндэслэсэн



Гроуп Финанс Аудит ХХК
Улаанбаатар 14250, Монгол Улс
2015 оны 02 дугаар сарын 09-ний өдөр

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2015 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг санхүүгийн